

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам, ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн “Хөвсгөл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ийг **2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт** цахимаар хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2022 оны 04 дүгээр сарын 7-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай
8. Хурлын даргаар Г.Уянгыг томилсугай
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Хурал зохион байгуулах комиссын дарга:
    - “Ард Пропертиз” ХХК, Гүйцэтгэх захирал Г.Уянга
  - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
    - “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хандаа
    - “ЕИТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Тооллогын комиссын дарга:
    - “Сноу Хилл” Консалтанси ХХН ахлах хуульч С.Намжилмаа
  - Тооллогын комиссын гишүүд:
    - “Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Д.Номин-Эрдэнэ
    - “Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Т.Оюун-Эрдэнэ
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Г.Сэлэнгэд даалгасугай.

ДАРГА



Л.ДАШЦЭРЭН